



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 1/81

Мандалговь

“Титанис пикчерс” ХХК-тай гэрээ
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй “Монголын баялаг 330” төсөл хөтөлбөрийн хүрээнд Дундговь аймгийн түүх соёлын болон байгалийн цогцолбор газрыг бүртгэн баримтжуулж мэдээллийн сан үүсгэх ажлыг 18,500,000 (арван найман сая таван зуун мянга) төгрөгөөр гүйцэтгэхээр ирүүлсэн үнийн саналаар “Титанис пикчерс” ХХК-тай нийт 18,500,000 (арван найман сая таван зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Гэрээний нөхцөлийн дагуу ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Титанис пикчерс” ХХК-ийн захирал (Г.Хишигжаргал)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Л.ДОРЖБАТ



4800150182